



## Улсын хилийн онол шүүхийн сэдвээр

### УЛСЫН ХИЛИЙГ ХАРУУЛААР ХАМГААЛАХ НЬ

ЗХУ (хуучин нэрээр)-ын хил хамгаалах онол урлагаас суралцаж, Зөвлөлтийн техник хэрэгслийг ашиглан улсын хил хамгаалалтыг зохион байгуулан явуулж түүнд тохирсон дүрэм зааврыг мөрдөж ирсэн Монголын хил хамгаалах түүхийн нэгэн зурvas үе бий. Тэр үед хилийн харуулын талаар ямар нэгэн дүрэм заавар байгаагүй бөгөөд Зөвлөлтийн хил хамгаалах онолоор хилийн харуул байх нь оновчгүй зүйл байлаа. Гэвч улсын хилийг харуулаар хамгаалсаар байв. Учир нь хүн ам цөөтэй, өргөн уудам нутаг дэвсгэртэй манай орны хил хязгаарын хувьд инженерийн төхөөрөмжлөл хангалтгүй, зам харгуй харилцаа холбоо муу хөгжсөн, хүн амын суурьшил сийрэг зэргээс эх орныхоо хил хязгаарын өвөрмөц онцлогийг тусгасан хамгаалалтын арга хэлбэр шаардлагатай байсан юм.

Улс орон зах зээлийн эдийн засгийн харилцаанд орохын хэрээр хилийн цагийн байдлын шинж байдал өөрчлөгдөн хилийн зөрчил идэвхжиж улсын хил хамгаалалтын арга хэлбэрийг өөрчлөх шаардлагатай болов. Түүнтэй холбогдуулан Монгол улсын хилийн тухай хууль, хил хамгаалалтын дүрмүүдийг шинэчлэн боловсруулж батлуулан хил хамгаалалтын эрх зүйн баримт бичгүүдийг шинэчиллээ. Ингэхдээ хилийн харуулыг хил хамгаалалтын үндсэн нэгж байхаар дүрэм зааварт тусгасан явдал хил хамгаалалтын бодит шаардлагыг үндэслэн монголын онцлогтой хил хамгаалалтыг зохион байгуулж явуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэв.

Ийнхүү монгол орны нийгэм эдийн засгийн хөгжил, байгаль цаг уур, соёл иргэншлийн онцлогт тохирсон хил хамгаалалтын уламжлалт хийгээд өвөрмөц аргыг албан ёсоор хэрэглэх боллоо.

Иймд улсын хилийг харуулаар хамгаалах зайлшгүй шаардлага, арга технологи тэдгээрийн онолын болон шинжлэх ухааны үндсийг хилчид сайтар мэдсэн байх шаардлагатай.

Түүхийн сурвалж бичгүүдээс одож байгаагаар манай эриний

өмнөх IV зууны үед монголчууд хилээ харуулаар хамгаалж байсан нь тодорхой бөгөөд түүнтэй хил залгаа байсан орнуудын хувьд ч мөн тийм маягийн хамгаалалт байсан байж болохоор байна. Хятадын их цагаан хэрэмийг хилээ хамгаалахын тулд байгуулсан бөгөөд тэр нь нэг талаас хилээ гадны халдлага довтолгоо чөлөөтэй нэвтрэхээс хамгаалж, нөгөө талаас түүнийг хяналт зохиох байр болгон ашиглаж байсан тухай зарим ном зохиолуудад<sup>1</sup>. өгүүлсэн байdag.

Одоо ч ул мөр арилаагүй байгаа Оросын өмнө, Монголын зүүн, өмнө, баруун хязгаараар үргэлжлэн байdag Чингис вал, Чингисийн хэрэм гэж нэрлэгдэн шороон далангуудаас авахуулаад Хятадын их цагаан хэрэм хүртэл өдий төдий баримтууд Азид төдийгүй Европд ч хил хязгаараа бат найдвартай байлгах, хот суурин газар нутгаа гадны халдлагаас хамгаалахын тулд хана хэрэм босгон харуул манаа гаргаж байсныг гэрчилж байна."Ялангуяа хот боомтуудыг эвдлэх аргад бүр мөсөн боловсорсон бөгөөд чулуу сум үсэргэн хаях зэвсгийг хэрэглэж байсан". "Нэгэн удаагийн байлдаанд Тулуй тушаал гаргаж чөдөр оньс хэмээх чулуудах зэвсэг 3000, үсэргэн хаях зэвсэг 300, ноцоо тос агуулсан тэсрэх помбо 700, хэрэм авирах шат 4000, чулуудах зэвсэгт хэрэглэх чулуу 2500 зэргийг бэлтгүүлж байжээ"<sup>2,3</sup> Энэ мэт баримтууд маш олон бий. Энэ нь Чингисийн үеийн байлдан дагуулалтын үед алхам бүртээ хэрэм цайзтай учирч байсан нь тэр үеийн улсуудын хил хамгаалалтын онцлогийг харуулж байна.

Хэрэм цайз барьж улс үндэстнийхээ нутаг дэвсгэрийг бүхэлд нь хамгаална гэдэг мэдээж хэцүү асуудал. Иймээс урт удаан хугацааны хөгжлийн явцад тэр нь сүүлдээ хилийн инженерийн төхөөрөмжлөл, хилийн манаа харуул болон хоёр салжээ.

Улс бүр хилийнхээ эргэн тойронд хана хэрэм босгосонгүй. Ихэнхдээ хилийн харуулаар хилээ хамгаалж байв. Энэ нь "...харуултай тулгарах", "...харуултай тулгарлаа", "...харуулаас барьж авлаа", "...харуул тавьлаа" гэсэн үгнүүд эртний ном зохиолуудад элбэг тохиолдогоос бүр тодорхой харагдаж байна.

Тэр үеийн нөхцөл байдлаас дүгнэн үзвэл хил хязгаартаа суурин газаргүй ихэвчлэн нүүдэллэн амьдардаг, дэд бүтэц хөгжөөгүй, байгаль цаг уурын онцлог, нийгмийн хөгжлийн шаардлагаар хэсэг бүлгээрээ нутаг бэлчээртээ захирагдан суухаас өөр хил хамгаалах боломжгүй байжээ.

Монгол улс өмнөд талаараа БНХАУ-тай, хойд талаараа ОХУ-тай хил залган оршдог бөгөөд хоёр хөрштэйгээ хиллэдэг хэсгийн хамгаалалтыг судалж дүгнэлт хийх нь онцгой ач холбогдолтой гэж үзнэ. Хятадын Монголтой хиллэдэг хэсгийн хамгаалалтыг Хүннүгийн

1. Г.Сүхбаатар. Монгол Нирүн улс. УЕ. 1992 он 110,239 дүгээр тал

2. Г.Е.Грумм-Гржимайло Западная Монголия и Урянхайский край Т-2 1926 стр 446

3. Амар Монголын товч түүх УБ. 1989 он 167 дугаар тал

үеэс авч үзэж болох боловч тэр үеийн хамгаалалтын талаар өгүүлэх гол баримт нь цагаан хэрэм бөгөөд өөр тодорхой зүйлгүй. Юань гүрний үед Хятад улс нь Монголын эзэмшилд байсан боловч Монголчууд төрсөн нутгаа цагаан хэрэмийн хойд талаар хамгаалж байсан гэсэн сонирхолтой мэдээ байдаг бөгөөд Хятадын зүгээс хамгаалалт ямар байсан нь тодорхойгүй.

Харин Монгол улс тусгаар тогтолцоо тэмцэн олж БНХАУ-тай албан ёсны хил тогтоосноос хойш бүр 1960-аад оны сүүлчээс Хятадын хил хамгаалалтын систем нэлээд тодорхой ажиглагдах болов.

Хилийн манааны ажиглалтаар хятаудууд 2-3 хүний бүрэлдэхүүнтэй, морь тэмээн уналгатай эсвэл машинтай манаа үе үе явуулж улсын хил, багана тэмдэг, хилийн зөрчлийн мөр ул байгаа эсэхийг шалгуулж газар оронд үзлэг хийлгэдэг, зарим газар нууц хянах байр барьж түүнээсээ хяналт зохиодог байсан бол сүүлдээ тусгай төхөөрөмжилсөн байранд олон хүн удаан хугацаагаар байрлан тодорхой хэсгийг хамгаалах явдал нэлээд өргөн дэлгэрсэн юм.

Уг байрууд нь тал газарт 25-30 метрийн өндөр цамхаг хэлбэртэй тоосгон барилга байдаг бөгөөд оройн хэсэгтээ хүмүүс амьдардаг өрөө, үүнийг тойруулж хяналт зохиход зориулагдсан тагт зарим нэг нь тагтан дээрээ дуран зоосон байдаг. Эдгээр нь хилээс 50 метрээс 5 км хүртэл зйтай байрладаг. Хилд ойр байгаа байр (цамхаг)-ын ойролцоо очиж хяналт хийж ажиглахад зарим үед моторын дуу гарч байдгаас үзэхэд гэрэл цахилгаанаар хангагдсан нэлээд тохижсон газар байдаг бололтой. Гол төлөв газар ухаж булсан утсан холбоотой(холбоо тавьж байгааг манааны хяналтаар тогтоосон) цамхагийн эргэн тойронд газрыг нь хагалж эсвэл шинээр хөрс суулган мөр хянах зурvas байгуулсан түүнийгээ өглөө бүр шалгаж байгаа нь ажиглагддаг.

Зарим үед хяналт зохиодог тагтан дээрээ 7-8 хүн гараад зогсож байдаг бөгөөд 3-5 хоногт машинтай хүмүүс ирээд буцдаг зэрэг нь тухайн байрлалд 3-5 хоногийн хугацаанд 10 хүртэл хүний бүрэлдэхүүнтэй манаа гарч 40 хүртэл км хилийн хэсэгт байнгын хяналт зохиох журмаар хамгаалдаг гэсэн дүгнэлтэд хүргэж байгаа юм.

Энэ нь тал газар байрладаг цамхагаас хилээ хамгаалдаг онцлог юм.

Харин уулархаг буюу өндөр уулын бүсэд уулын орой дээр өмнө өгүүлсэн цамхагийн оройн хэсэгтэй адил барилгыг барьж тэндээсээ хяналт зохиож байгаа нь ажиглагддаг.

Тал хээрийн бүсэд 8-16 метрийн өргөн мөр хянах зурvas төрөн

хашаа барьж байгуулан хил хамгаалтадаа ашиглаж байна. Улархаг райондоо ийм байгууламж ховор. Энэ мэтээр Монгол улсын өмнөд хилийн эргэн тойронд нэгэн ижил ийм маягийн байгууламж, ийм маягийн хамгаалалт байна. Хянах байр цамхагуудаас зохиож байгаа хяналт нь үндсэндээ манай хилийн харуул шиг хилд ойртон байрлаж, тасралтгүй ажиглалт хийдэг, инженерийн байгууламжуудаа морь тэмээн уналгатай манаагаар үе үе шалгуулдаг. Машинтай манаагаар сумангийнхаа хариуцсан хэсгийн бүх багана тэмдгийг сар улирал тутамд, заримдаа сард 2 удаа шалгадаг.

Ийнхүү БНХАУ манайхтай залгасан хилийнхээ нэлээд хэсгийг хилийн харуул пост манаагаар хамгаалдаг байна.

Хятадын хил орчмын нутаг дэвсгэрийн байдал, түүний хөгжил, тэнд зохион байгуулагдаж байгаа хил хамгаалалтын арга хэлбэр нь манай өмнөд хилийн хамгаалалттай адил байгаагаас үзэхэд хоёр орны хил хамгаалалтын ижил төстэй байдал нь хил орчмын нутаг дэвсгэрийн газар зүйн онцлог, хүн амын нягтрал суурьшил, дэд бүтцийн хөгжил, хамгаалалтын зорилго зэргээс шалтгаалдаг гэдэг дүгнэлтэд хүргэж байна.

Монгол-Оросын хилийн онцлог нь **нэгдүгээрт**: ой тайга, уул нуруу голлосон байгальтай, **хоёрдугаарт**: ус гол намаг шавар ихтэй, **гуравдугаарт**: ан амьтан элбэгтэй, **дөрөөдүгээрт**: битүү тайгын биш хэсэгтээ хилийн орчим айл малтай, **таевдугаарт**: хилийн хоёр талд орших субъектүүд нь олон жил үргэлжилсэн найрамдал сайн хөршийн харилцаатай, **зургадугаарт**: хилийн хоёр талд оршин суух иргэдийн зарим хэсэг нь садан төрлийн холбоотой зэрэг онцлогтой.

Дээрх онцлогууд нь тухайн хилийн хамгаалалтын ижил төстэй байх нөхцөлийг бүрдүүлсэн гэж үзэх үндэстэй юм.

Архивын баримтаас үзэхэд 1800-аад оны үед орос манайхтай залгасан хилээ харуулаар хамгаалж байсан нь тодорхой байдаг.

Төр гэрэлтийн арван гуравдугаар он буюу 1833 оны гуравдугаар сарын 29-нд Ульхан зэрэг дөрвөн харуулыг захирах залан Ойдовцэрэн Цэцэнхан аймгийн орос зүгийн харуулыг дааж захирах засгийн тэргүүнд бичгээр **мэдээллэхдээ**:

"...Жасаа таны газраас тогтоон тушаасныг дагаж харьяат захирах дөрвөн харуулын занги, хүнд нарыг тус тусын эсрэг орос харуул лугаа (харуултай П.Д) найртай ёсоор нэг жилд нэг удаа мэдээ авахуулахаар илгээсэн түшмэл цэргийн нэр, уналга зэргийг бичгийн хойно жагсаан бичиж үүний тул өргөв. Ульхан харуулын хүнд (харуул зангийн орлогчийн албан тушаал П.Д) Аюурзана цэрэг Оргийг дагуулж хүн бүр нэжгээд морьтойгоо эсрэг орос харуулаас мэнд мэдээ

авчээ..." (МУТТА Ф152 хн 1896) гэсэн баримт байгаа нь орос өмнөд хилээ харуулаар хамгаалж тэр нь хөрши орныхоо хилийн харуултай харилцан ажилладаг эрх бүхий хил хамгаалалтын нэгж байсныг харуулж байна.

Улс орны нийгэм эдийн засгийн хөгжил шинжлэх ухаан техник технологийн дэвшлийн хэрээр хил хамгаалалтын арга хэлбэр бүтэц, зохион байгуулалт улам боловсронгуй болон өөрчлөгдөж байна. Үүнийг оросын хил хамгаалалтын хүч хэрэгсэл байршил нягтрах үйл ажиллагаа зэргээс харж болно.

Оросын хил хамгаалалтын хамгийн доод нэгж – хилийн застав нь 50 хүнтэй, буудлагын зэвсгээр зэвсэглэсэн, гурван машин, 1 мотоцикл, холбоо дохионы хэрэгслээр иж бүрэн хангагдсан, хариуцан хамгаалдаг хилийн хэсгийн урт нь дундажаар 10 км байдаг. Хүн ам шигүү суурьшдаг, хилийн зөрчил их гардаг, хамгаалалтад авахад хүндрэлтэй онцлог чиглэлийн застав 3 км, хилийн цагийн байдлын өрнөлт багатай харьцангуй тайван, хил орчимдоо нягтрал багатай суурьшдаг зам харилцаа муутай, нөлөө багатай газартаа 50-70 км хэсгийг хариуцан хамгаалдаг.

Хилээ инженерийн талаар маш сайн төхөөрөмжилсөн ялангуяа анхаарал татсан чиглэлдээ 2-3 давхар өргөст утсан хашаа (дохиоллын систем бүхий) мөр хянах зурvas, манааны жим, машины замтай, заставаас гарсан 1-2 хүний бүрэлдэхүүнтэй манаа хяналт зохиоход зориулагдсан харуулын цамхагуудтай.

Хилийн хамгаалалтдаа 10 гаруй төрлийн манаа ашигладаг бөгөөд түүний бүрэлдэхүүн нь ихэвчлэн 1-3 хүнтэй, хоногт 8-аас илүүгүй цагийн үүрэг гүйцэтгэдэг. Харин ОХУ-ын Тува улстай манай улсын хиллэдэг хилийн хэсэг дээр байрладаг оросын заставуудын хувьд хариуцсан хэсэг нь харилцан адилгүй энэ хэсгийн нийт 1000 гаруй км хэсэгт зургаахан застав байгаа ба нэг заставын хариуцсан хэсэг дунджаар 200 км байна. Эдгээр заставууд хилээ хамгаалахдаа гол төлөв иргэдийн мэдээллийн мөрөөр ажил зохиох, орон нутгийн иргэдийн дунд хилийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг шалгах, заставынхаа эсрэг талд байнга хилийн манаа гаргах хяналт тавих зэрэг үйл ажиллагаа явуулж байна.

АНУ, Япон, Англи, Франц, Герман зэрэг газар зүйн таатай орчинд байрласан өндөр хөгжилтэй орнуудын хил хамгаалалтын агуулга шинж чанар манай орныхоос эрс ялгаатай. Ер нь Монгол улсын газар зүйн байрлал, нүүдлийн соёл иргэншил дэлхийн ихэнх орноос эрс ялгаатай учир тэдний хил хамгаалалттай харьцуулахад төвөгтэй юм.

Иймд өөрийн орны хил хамгаалалтын орчин нөхцөлтэй ойролцоо нөхцөлд хилээ хамгаалдаг орнуудын хил хамгаалалтыг судлан дүгнэлт хийв. Энэ явцад хил хамгаалалтын арга хэлбэр ямар байх нь:

1.Хил залгаа улстай тогтоосон харилцаа (сайн хөршийн найрамдалт харилцаа юу, бие биедээ үл итгэлцсэн харилцаа юу)

2.Газар орны байдал (уул, тал, говь, цөл, ой тайга, эсвэл нуур, гол мөрөн үү ?)

3.Хил орчмын нутаг дэвсгэрийн хөгжил (хил орчмын хүн амын суурьшил нягтралтай, нягтрал багатай, хот суурин газар олонтой, цөөнтэй, дэд бүтэц хөгжсөн, хөгжөөгүй, байнга оршин суух амьдрах нөхцөл сайтай муутай)

4.Улс орны хөгжлийн түвшин (шинжлэх ухаан техник, эдийн засгийн хөгжил ард түмний амьжиргааны түвшин гэх мэт )

5.Хүч хэрэгслийн боломж (Хүний тоо, зэвсэг, техник, дуран харааны ба холбооны хэрэгслийн хүчин чадал) зэрэг хүчин зүйлүүдээс шалтгаалдаг гэсэн зүй тогтол ажиглагдаж байна.

**Үргэлжлэл бий.**

**ХЦС-ийн дэд захирал,  
дэд профессор, хошууч генерал П.Даш**